

ТҮНШЛЭЛД СУУРИЛСАН ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ

ТӨСЛИЙН ТУХАЙ:

Эдийн засгийн хөгжлийн гол түлхүүр нь ур чадвартай ажиллах хүч юм. Монгол улсад аж үйлдвэрийн салбар төрөлжин хөгжиж, үйлдвэрлэлд шинэ техник технологийг нэвтрүүлэхийн хэрээр хөдөлмөрийн зах зээлд техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт (МБС)-аар бэлтгэгдсэн мэргэжилтэй ажилтны эрэлт хэрэгцээ нэмэгдэж байна. Тиймээс, Монголчууд МБС-ыг сонгон ур чадвартай мэргэжилтэй ажилтан болбол хөдөлмөр эрхлэх, эдийн засагт хувь нэмрээ оруулах боломж их байна.

Төсөл нь Монголын МБС-ын тогтолцоог тогтвортой хөгжүүлэхэд дараах чиглэлд дэмжин ажиллаж байна:


- 7 Чадамжийн Төв (ЧТ)-ийг төрөлжүүлэн хөгжүүлэх
- МБС-ын багшийг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах тогтолцоог хөгжүүлэх
- МБС-ын санхүүжилтийн механизм, эрхзүйн орчныг сайжруулахад зөвлөх

Төсөл нь 2013-2019 онд хэрэгжсэн "Ашигт малтмалын салбар дахь түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын төсөл"-ийн үр дүнд үндэслэгдсэн.

ЗОРИЛГО:

Техникийн мэргэжлийн чиглэлээр мэргэжлийн боловсрол, сургалтын гүйцэтгэл тогтвортой сайжирсан байна.

Захиалагч	ХБНГУ-ын Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яам (BMZ)
Хамтран санхүүжүүлэгч	<ul style="list-style-type: none"> • БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (KOICA) • Австралийн Гадаад Хэрэг, Худалдааны Яам (DFAT) (2021.12 хүртэл)
Төсөл хэрэгжих бүс, нутаг	Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг, Дорнод аймаг, Өмнөговь аймаг, Завхан аймаг
Хэрэгжүүлэгч байгууллага	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам (2022.03-с хойш)
Хугацаа	2019.03 - 2023.12





Чадамжийн
төвүүд

558 ▶ ЧТ-ийн ажилтнууд чанарын удирдлагын 9 модуль сургалтад хамрагдсан.

Долоон МБС-ын байгууллагыг Монгол улсын МБС-ын тогтолцоонд мэдлэг, ур чадвар, инновацыг түгээн дэлгэрүүлэгч төрөлжсөн Чадамжийн төв болгон хөгжүүлж байна.

ЧТ-ийн үйл ажиллагаа:

- Чанартай сургалт
- МБС-ын багшийн сургалт
- Аж ахуйн нэгжийн захиалгат сургалт
- Ур чадварын үнэлгээний төв
- Дэлхийн ур чадварын тэмцээний бэлтгэлийн төв

ЧТ-үүдэд чанарын удирдлагын системийг бий болгох:

Дижитал хэрэгслүүдийг хөгжүүлэв:

- Хэрэглэгчтэй харилцах удирдлагын систем (CRM)
- Баримт бичгийн удирдлагын систем (DMS)
- Тоног төхөөрөмж, эд хөрөнгийн удирдлагын систем (TAMS)



МБС-ын
багшийн
хөгжлийн
тогтолцоо

363 ▶ 122 хүний нөөцийг чадавхжуулах дадлагад чиглэсэн сургалтад МБС-ын багш, ажилчид хамрагдав.

Төсөл нь МБС-ын багш нарыг анхлан бэлтгэх болон мэргэшүүлэн тасралтгүй хөгжүүлэх тогтолцоог хөгжүүлэхэд дэмжин ажиллаж байна.

МБС-ын багш анхлан бэлтгэх:

ЮНЕСКО ЮНЕВОК-ын стандартын хөтөлбөртэй "МБС-ын багш" магистрын хөтөлбөрийг Техник Технологийн Дээд Сургууль дээр туршилтаар хэрэгжүүлж эхэлсэн.

МБС-ын багш нарыг мэргэшүүлэх:

Мэргэжлийн болон заах аргазүйн ур чадварын үнэлгээ хийж, үр дүнд тулгуурлан багш мэргэшүүлэх сургалтын багцуудыг 7 мэргэжлийн хүрээнд боловсруулсан.



МБС-ын
хууль,
эрхзүй

69 ▶ ЧТ, хувийн хэвшил, түнш байгууллагуудын ажилтнууд ЧТ-ийн тогтвортой санхүүжилт сургалтад хамрагдав.

ЧТ-үүдийн эрхзүйн орчныг сайжруулахад МБС-ын хуулийн шинэчлэлд чанарын удирдлага, нийгмийн түншлэл, багшийн хөгжил, ЧТ-үүдийн зохион байгуулалт, санхүүжилт, жөндөр сэдвүүдэд техникийн санал, зөвлөгөө өгсөн.

ЧТ-үүдийн тогтвортой санхүүжилтийн механизмыг бий болгоход, үйлдэлд суурилсан өртгийн тооцоололд тулгуурлаж МБС-ын санхүүжилтийн томьёо болон дагалдах дижитал арга хэрэгслийг боловсруулсан.

Томьёог ашиглан Монгол улсын засгийн газар тодорхой мэргэжил, бүс нутгийн ялгааг онцлох, эдийн засгийн стратегийн хэрэгцээнд үндэслэн МБС-ын салбарыг дэмжих боломжтой.

ДИГИТАЛЧЛАЛ

Салбарын үйл ажиллагааг хянаж үнэлэх, дүн шинжилгээ хийх, төлөвлөлт, шийдвэр гаргалтад дэмжлэг болох үндэсний МБС-ын цогц мэдээллийн удирдлагын систем, МБС-ын сургалт удирдлагын систем буюу Moodle-д суурилсан цахим сургалтын платформыг хөгжүүлэв.

Нийтэлсэн:

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны
Нийгэмлэг

Холбоо барих:

Беате Диппмар
"Түншлэлд суурилсан техникийн болон
мэргэжлийн боловсрол, сургалт" төсөл
Найман зөвхис барилгын IV давхар, Сөүлийн
гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14251,
Монгол улс
70005340
beate.dippmar@giz.de
www.giz.de/mongolia

Огноо:

Дизайн/Зураг:

2022 оны 10-р сар

Монгол дахь GIZ

Нийтлэлийн агуулгыг Монгол дахь
GIZ хариуцна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
(2022 оны 3-р сар хүртэл)

Хамтран

хэрэгжүүлэгч:



Захиалагч:

Боловсрол, шинжлэх ухааны яам
(2022 оны 3-р сараас хойш)

ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа
хөгжлийн яам (BMZ)

